

## ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 5–8 Зохицуулалтын мэдээ
- 9–10 Ярилцлага
- 11 Тайлбар ба зөвлөмж
- 12–14 Тогтвортой санхүүжилт
- 15–16 Компанийн засаглал, комплайнс
- 17–18 Финтек ба регтек
- 19–23 Судлаачийн индэр
- 24–25 Үл хөдлөх эд хөрөнгийн хөрөнгө оруулалтын сан гэж юу вэ?
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## ШИНЭЭР БАТАЛСАН ЖУРАМ

Улсын Их Хурлаас 2024 оны 05 дугаар сарын 16–ны өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, улмаар зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа болон мөнгөний зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болох банкнаас гаргах хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихтай холбоотой эрх зүйн зохицуулалт тус тус бий болсон.

Тус хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 03–ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журам”–ыг, 07 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”–ыг тус тус баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээ.

### ХУВЬЦААНЫ ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

#### 1. Журмын бүтэц, зохицуулах харилцаа

Тус журам нь 11 бүлэг, 3 хавсралтаас бүрдэх бөгөөд хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах, түүний үйл ажиллагаа, программ хангамжид тавигдах нөхцөл шаардлагыг тогтоох, хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд тавигдах гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ, хугацаа болон иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага, түүний хөрөнгө оруулах хөрөнгийн дээд хэмжээ, хязгаарлалтыг тогтоохтой холбогдох харилцааг зохицуулна.

#### 2. Гарах үр дүн

Уг журам хэрэгжсэнээр олон улсын хөрөнгийн зах зээл дээрх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэх, хөрөнгө оруулалт нэмэгдэх, гарааны компани болон жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид банкны зээлээс өөрөөр буюу хөрөнгийн зах зээлээр дамжуулан урт хугацаат санхүүжилт татах боломж бүрдэх давуу талтай.



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### Нийгмийн бонд

Social Bonds

*Нийгэмд эерэг үр дүн авчрах шинэ болон одоо хэрэгжиж байгаа төслүүдэд хөрөнгө босгоход ашигладаг бонд.*



**ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН**  
НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

Нэмж, сайжруулсан хоёр дахь хэвлэл

### Нүүрстөрөгчийн эрх

Carbon Credits

Тодорхой хэмжээний нүүрстөрөгчийн давхар исэл эсвэл бусад хүлэмжийн хий ялгаруулахыг зөвшөөрсөн гэрчилгээ. Хүлэмжийн хийн ялгаруулалт тогтоосон хязгаарыг давсан тохиолдолд кредит авах ёстой. Нэг кредиттэй байна гэдэг нь нэг тн нүүрстөрөгчийн давхар исэл эсвэл бусад хүлэмжийн хийг ялгаруулах боломж олгодог. Хэмнэсэн кредитээ нүүрстөрөгчийн бирж эсвэл зах зээл дээр зарж болно.

*Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аливаа гэрээний харилцаанд оролцогч талууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, үүний улмаас ихээхэн хэмжээний хохирол учрах эрсдэл өндөр байдаг тул учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, санхүүгийн аюулгүй байдлыг хангах, гэрээний талууд хоорондын итгэлцлийг нэмэгдүүлэх зорилгоор баталгааг өргөнөөр ашигладаг бөгөөд энэ нь үүргийн гүйцэтгэлийг хангуулах санхүүгийн чухал арга хэрэгслүүдийн нэг юм.

Олон улсад даатгалын компаниуд нь баталгааны зах зээлийн томоохон тоглогч байж, төрөл бүрийн салбарын бизнесийн гэрээ байгуулах болон тусгай зөвшөөрөл олголт, зохицуулалтын шаардлагын нэг хэсэг болж, санхүүжилтийн уян хатан байдал, илүү үр ашигтай зардлын удирдлагын тогтолцоог бий болгоход томоохон үүргийг гүйцэтгэж ирсэн.

“Surety” гэж нэрлэгддэг энэхүү даатгагчийн баталгаа нь өндөр хөгжилтэй орнуудын хувьд түгээмэл хэрэглэгдэж, бүтээгдэхүүн хөгжлийн төрөл бүрийн үе шатыг дамжин хөгжиж ирсэн бол хөгжиж буй орнуудын хувьд энэ нь шинээр гарч ирж буй ойлголт юм. Тодруулбал, даатгагчийн баталгаа нь анх 19-р зуунд хөгжингүй орнуудад, ялангуяа АНУ-д ашиглагдаж эхэлсэн бөгөөд 1887 онд American Surety Company нь барилгын гэрээнд баталгааны бондыг гаргасан анхны компани болсон бол 1890-ээд оноос Дэлхийн даатгалын томоохон зах зээлийн нэг Lloyd's of London нь даатгалын баталгааг гаргаж эхэлсэн түүхтэй. Өнөөдрийн байдлаар, даатгагчийн баталгаа нь ихэвчлэн барилга, үйлдвэрлэл, эрчим хүч, дэд бүтцийн салбарт түлхүү хэрэглэгдэж, төслүүдийг тохиролцсон ёсоор гүйцэтгэх, төлбөрийг хийх, хууль ёсны шаардлагыг хангах баталгаа болж байна.

Үүргийн гүйцэтгэлийг хангуулах санхүүгийн арга хэрэгслийн хувьд даатгагчийн баталгааг “letter of guarantee” буюу арилжааны банкны баталгааг орлох санхүүгийн хэрэгсэл гэж хэлж болно. Банк эсхүл даатгагчаас гаргаж буй баталгаа нь үүрэг гүйцэтгэгчийг гэрээний дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх баталгааг өгдгөөрөө ижил боловч банкны хувьд баталгаа гаргахдаа үүрэг гүйцэтгэгчийн зээлжих чадварыг харгалзан үздэг бол (тухайлбал, гүйцэтгэгч нь хангалттай хэмжээний хадгаламж байршуулсан эсэх, барьцаа хөрөнгөтэй эсэх) даатгагчийн баталгааны хувьд гүйцэтгэгчийн эрсдэлийг нарийвчлан үнэлэх буюу тухайн төслийг гүйцэтгэх чадамж, туршлага, эрсдэл зэргийг харгалзан үздэгээрээ ялгаатай.

Үүнээс гадна даатгагчийн баталгаа нь дараах шинж чанараараа уламжлалт даатгалын бүтээгдэхүүнээс ялгаатай байдаг. Үүнд:

- ◆ Даатгал нь ирээдүйн эрсдэлийг бууруулах хэрэгсэл бөгөөд даатгалын үнэлгээний хүрээнд учирсан эрсдэл, хохирлыг нөхөн төлөх зорилготой

байдаг бол баталгаа нь үүргийн гүйцэтгэл хангагдаагүй үед баталгааны үнийн дүнг олгодог.

- ◆ Баталгааны гэрээний харилцаанд даатгагч, гүйцэтгэгч, гүйцэтгүүлэгч 3 тал оролцдог бол даатгалын гэрээнд даатгагч, даатгуулагч 2 тал оролцдог.
- ◆ Баталгааны гэрээний дагуу үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаарддаг бол даатгалын гэрээнд нөхөн төлбөрийг олгох, олгохгүй нөхцөлийг гэрээнд тодорхой зааж өгсөн байдаг.

Эдгээр онцлог бүхий дээрх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад хууль тогтоомжийн хүрээнд нарийвчлан зохицуулдаг бөгөөд улс орнуудын даатгагчийн баталгааны талаарх хууль эрх зүйн зохицуулалтын мэдээлэл дараах байдалтай байна. Үүнд:

Бүгд Найрамдах Солонгос улсын хувьд баталгааны даатгал нь 1970–аад оноос хөгжиж ирсэн бөгөөд Солонгос улсын цорын ганц баталгааны даатгалын цогц үйлчилгээ үзүүлэгч нь БНСУ–ын Засгийн газрын байгууллага болох Солонгосын Хадгаламжийн Даатгалын Корпорац (KDIC) 93 хувийг нь эзэмшдэг “Сөүлийн баталгааны даатгал (SGI)” компани юм.

БНСУ–д баталгааны даатгалд батлан даалтын бонд, зээлийн даатгал хамаардаг. Улмаар батлан даалтын бонд нь гурван талт гэрээ ба үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн үүргийг батлан даадаг бол зээлийн даатгал нь харилцагч зээлээ төлөөгүйн улмаас учирсан хохирлыг нөхөн төлдөг байна. Баталгааны даатгалын бүтээгдэхүүн нь зээлжих чадвар хангалтгүй гүйцэтгэгч нарын болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ихээхэн дэмжлэг үзүүлдэг онцлогтой даатгалын бүтээгдэхүүн юм. Баталгааны даатгалын үйл ажиллагааг Даатгалын бизнесийн тухай, Арилжааны тухай болон Иргэний тухай хуулиудаар тус тус зохицуулсан байна.

Бүгд Найрамдах Энэтхэг улсын хувьд баталгааны даатгал нь шинэ тутам үйлчилгээ бөгөөд тус улсын Даатгалын зохицуулалт, хөгжлийн газраас Баталгааны даатгалын бизнесийг зохицуулах, хөгжүүлэх зорилгоор холбогдох журмыг батлан 2022 оноос эхлэн мөрдөн ажиллаж байна.

Даатгалын тухай хуулийн дагуу ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын компаниуд тус журамд заасан шалгуурыг хангасан

тохиолдолд Баталгааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд журамд баталгааны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд санхүү, төлбөрийн чадвар, бүтэц, зохион байгуулалтын хувьд тавигдах шаардлага, мөн гаргаж болох баталгааны дээд хэмжээг тус тус заасан байна. Түүнчлэн даатгалын компаниуд нь даатгалын баталгааны бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахаас өмнө холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлж, мэдэгдэх бөгөөд гаргасан баталгааны тайланг Энэтхэгийн даатгалын мэдээллийн санд хүргүүлдэг зохицуулалттай байна.

Сингапур улсад даатгалын баталгааны үйл ажиллагааг 1997 онд батлагдсан Санхүүгийн баталгааны даатгалын журмаар зохицуулдаг. Тус улсын зохицуулалтын дагуу баталгааны даатгалыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зээлжих зэрэглэлийн агентлагаас олгосон үнэлгээ бүхий эсвэл эрх бүхий байгууллагаас тогтоосон шаардлага хангасан даатгалын компани нь баталгаа гаргах боломжтой байна. Тухайлбал, баталгаа гаргах даатгалын компанийн шаардлагатай хамгийн бага хөрөнгийн хэмжээг 75 сая ам.доллороос багагүй буюу түүнтэй тэнцэхүйц хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх, мөн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зээлийн үнэлгээний агентлагаас олгосон шилдэг 3 ангилалд багтсан зэрэглэл эсвэл түүнтэй тэнцэх хэмжээний үнэлгээтэй байхаар тусгасан байна.

Дээрх улс орнуудын туршлагаас харахад зарим улсад даатгагчийн баталгааг зөвхөн 1 компани гаргадаг бол зарим улсад ердийн даатгалын компаниуд гаргах боломжтой байх зэргээр даатгагчийн баталгааны зохицуулалтыг улс орон бүр өөр өөрийн онцлогт тохируулан бий болгосон байна.

Харин манай улсын хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендерт оролцогч нь тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа болон урьдчилгаа төлбөрийн баталгааг зөвхөн Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас, банкны баталгаагаар ирүүлэхээр тусгасан байсан нь даатгагчаас баталгаа, батлан даалт гаргах боломжийг хязгаарлаад байсан юм. Өөрөөр хэлбэл, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд мөн хувийн хэвшил, олон улсын төсөл хөтөлбөрүүд нь тендерийн үйл ажиллагаандаа зөвхөн банкны баталгааг хүлээн зөвшөөрч, ийнхүү банкаар баталгаа гаргуулах нь хэвшиж тогтсон ойлголт байсаар ирсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Даатгалын тухай хуулиудад даатгагч нь холбогдох этгээдээс бусад этгээдэд баталгаа, батлан даалт гаргах нэмэлт өөрчлөлтийг оруулж баталснаар төрийн худалдан авах ажиллагаанд даатгагчийн баталгааг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн, энэхүү өөрчлөлтөөр ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг даатгагчийн баталгаагаар гаргах боломж бүрдээд байна.

Үүний дагуу, хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 46 дугаар тогтоолоор “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд уг журмаар даатгагч баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд санхүү, төлбөрийн чадвар болоод удирдлага, зохион байгуулалтын хувьд тавигдах шаардлага, гаргаж болох баталгааны хэмжээ, үүсэж болзошгүй эрсдэлээс хэрхэн сэргийлэх зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан. Ийнхүү хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр мөрдөгдөж, түүний хэрэгжилтийг хангахад шаардлагатай зохицуулалтын журам батлагдсанаар даатгалын компаниудын баталгаа гаргах хууль эрх зүйн орчин бүрэн бүрдсэн.

байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус зөвлөлөөс баталгааны гэрээний загвар, нөхцөл, хураамжийн хэмжээ зэргийг боловсруулан баталж, компаниуд ижил үнийн бодлогыг барьж ажиллаж байна. Улмаар 2024 оны байдлаар нэр бүхий даатгалын 5 компани 22.5 тэрбум төгрөгийн 336 баталгаа гаргасан үзүүлэлттэй байна.

Ийнхүү даатгалын компаниуд баталгаа гаргаж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд худалдан авах ажиллагаандаа даатгагчийн баталгааг ашиглаж эхэлснээр иргэд, аж ахуйн нэгжийн хувьд баталгааг олон эх үүсвэрээс гаргуулах, учирч буй санхүүгийн хүндрэлийг илүү эдийн засгийн үр өгөөжтэй байдлаар шийдвэрлэх ач холбогдолтойгоос гадна нөгөө талаар даатгалын салбарын эрсдэлийн удирдлага, санхүүгийн чадамжийг дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг эерэг үр нөлөөтэй. Иймд тус Хороо нь даатгалын салбарт нэвтэрч буй шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болох даатгагчийн баталгааг амжилттай нутагшуулах, цаашид даатгалын салбарын гаргаж буй баталгааны хэмжээг нэмэгдүүлэх, олон улсын хөгжлийн жишигт нийцсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, улмаар даатгалын салбарын нийгэм эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх чиглэлээр даатгалын салбарын оролцогчидтой хамтран ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар баталгаа гаргах үйл ажиллагаа эрхэлж буй даатгагч нар хамтран Хамтын удирдах зөвлөлийг



## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ



### ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР ТОЛЬ ШИНЭЧЛЭГДЭН ХЭВЛЭГДЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Санхүү эдийн засгийн их сургууль, хамтран "Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь: Өнгөрсөн, Одоо, Ирээдүй" хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж, бэхэжсэний 100 жилийн ой, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн 100 жилийн ой, Үнэт цаасны хороо буюу одоогийн Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсаны 30 жилийн ойг тус тус тохиолдуулан "Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь бичиг"–ийг шинэчлэн боловсруулж, 2024 онд цахим хуудас (etoli.mn)–ны нээлтийг хийж байсан. Харин энэ удаад шинэчилсэн тайлбар толь бичгийг хэвлэмэл хэлбэрээр нь гаргаж, олон нийтийн хүртээл болгосны дээр шинэчлэлийн ажлыг илүү үр дүнтэй, хүртээмжтэй болгохын тулд салбарын мэргэжилтнүүд, судлаачид, санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдыг хамруулсан хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Энэ үеэр өмнөх туршлагыг үнэлэн, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, тайлбар толийн агуулгыг баяжуулж, олон улсын жишигт нийцүүлэх, хэрэглэгчдийн саналыг идэвхтэй тусгах нь чухал гэдгийг онцлохын зэрэгцээ тайлбар толийг шинэчлэх ажил нэг удаагийн төдий бус цаашид тасралтгүй үргэлжлэх, хэрэглэгчдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаар боллоо. Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, СЭЗИС–ийн нийт 37 эрдэмтэн багш, судлаач, салбарын мэргэжилтнүүд хамтран гүйцэтгэсэн энэхүү тайлбар толь нь нийт 11 бүлэг, 3650 орчим англи, монгол нэр томьёоны тайлбараас бүрдсэн бөгөөд мэргэжлийн хэллэгүүдийн ойлголтын зөрүүг арилгаж, эдийн засаг,

санхүүгийн зохицуулалтын баримт бичиг, гэрээ хэлцэл, сургалт, судалгаанд нэр томьёог нэг утгаар ойлгох, ашиглах боломжийг бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм. Мөн цахим тайлбар толь бичигт шинэ үг нэмэх, нэр томьёог сайжруулах, өөрчлөх санал хүсэлт илгээх боломжтой цэс нэмсэн нь цаашид үгийн сан өргөжих, нэр томьёоны орчуулга сайжрах, тасралтгүй хөгжих боломж бүрдэх давуу талтай.

### ХУУРАМЧ ВИРТУАЛ ХӨРӨНГӨ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЕ

Дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээ өргөжиж буйтай зэрэгцэн "шинэ технологи" гэх тодотголтой хуурамч

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖ УУ?!

**ХАВХ УУ?**

Технологид суурилсан, богино хугацаанд өндөр ашиг амлаж буй:

- Хөрөнгө оруулалтын багц;
- Виртуал хөрөнгө;
- Үнэт цаас;
- Шинэ төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэл

зэргийг санал болгож буй тохиолдолд тухайн үйл ажиллагааны талаар нарийвчлан судлахыг зөвлөж байна.

Учир нь виртуал хөрөнгө эсвэл цахим хөрөнгө оруулалтын хэрэгсэл хуурамчаар санал болгодог "Rug & Pull" гэх залиланд өртөх эрсдэлтэй юм.

www.frc.mn

бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын хэрэгслүүд олширч, хөрөнгө оруулагчдад эрсдэл дагуулж байна.

Үүний түгээмэл жишээ болох “Rug and Pull” залилангийн талаарх мэдээлэлтэй танилцана уу.

**Rug&Pull залилангийн гол шинжүүд юу вэ?**

- Тухайн бизнесийн үүсгэн байгуулагч, баг, хамт олны мэдээлэл нууц;
- Бодит байдлаас хол, өндөр өгөөж;
- Ямар ч эрсдэлгүй гэж амлах;
- Хиймэл оюун ухаан, бот гэх мэт шинэ технологийг санал болгох;
- Виртуал хөрөнгийн танилцуулга нь хэт ойлгомжгүй, техникийн үг хэллэг хэт ашигласан;
- Хөрөнгө оруулалтын стратеги, үйл ажиллагааны мэдээлэл нь тодорхой бус.

Энэ төрлийн залилан нь хуурамч виртуал хөрөнгө санал болгох, технологид суурилсан цахим хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулалт татах зэргээр зайнаас хөрөнгө гатан төвлөрүүлж, хэсэг хугацааны дараа төслийг зогсоон, алга болдог.

Иймд, иргэн та аливаа хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа тухайн байгууллагын үйл ажиллагаа, үүсгэн байгуулагчид аливаа зохицуулагч байгууллагаас тусгай зөвшөөрөлтэйгөөр эссхийг сайтар нягтлахыг зөвлөж байна.

www.frc.mn

## “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ 2024 ОНЫ ТАЙЛАНГИЙН НЭГДСЭН СУДАЛГАА ГАРЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсанаар нээлттэй хувьцаат компаниуд уг кодексийг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахад 2023 оны жилийн эцсийн байдлаар кодексийн хэрэгжилтийн үнэлгээ 65.0 хувийн гүйцэтгэлтэй байсан. Мөн тайлангийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг өгч, улмаар биелэлтийг давтан үнэлэхэд 2024 оны жилийн эцсийн байдлаар кодексийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 79.1 хувийн гүйцэтгэлийг үзүүлэв. Үүнийг өмнөх онтой харьцуулахад 14.1 хувиар өссөн байна.

Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж, үр дүнд нь суурилан компанийн засаглалын зэрэглэлийг тогтоох, үнэлгээний нэгдсэн судалгааг боловсруулж, олон нийтийн хүртээл болгох нь тухайн салбар дахь компанийн засаглалын хүрээний эрсдэл, сорилт, боломж болоод хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, салбартаа тэргүүлэгчдийг тодруулах зэрэг давуу талтай бөгөөд цаашид компаниудад өөрийн засаглалын түвшинг салбарын хэмжээнд харьцуулах, улмаар сайжруулахад нь туслах сайн жишиг болохоос гадна хөрөнгө оруулагчийн хувьд шийдвэр гаргалтад нь нэн шаардлагатай эрсдэлийн



дүн шинжилгээнд ашиглах компанийн засаглалын чанарыг тоон үзүүлэлтээр илэрхийлэх боломжийг бүрдүүлж өгөх ач холбогдолтой.

## САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2025 оны I улирлын ээлжит хуралдаан боллоо. Хуралдааныг Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн даргалж, Сангийн сайд Б.Жавхлан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн болон холбогдох бусад албан тушаалтнууд оролцлоо.

Хуралдаанаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаатай холбоотой журмын өөрчлөлт, шинэчлэлт, банк бус санхүүгийн байгууллагын салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон макро эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн гүйцэтгэл, эдийн засгийн өнөөгийн төлөв зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Мөн энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн тогтвортой байдлыг хангах, зээлийн хэт өсөлтийг хязгаарлаж, иргэдийн өрийн дарамтыг бууруулах, санхүүгийн байгууллагын эрсдлийг бууруулах болон төлбөрийн чадварыг сайжруулах чиглэлд



авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулав.

Хуралдаанаас нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чиглэлд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд холбогдох журмуудад өөрчлөлт оруулахаар шийдвэрлэлээ.

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ ГАРГАХ, АРИЛЖААЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛО



Санхүүгийн зохицуулах хороо “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”-ын талаарх зохицуулалт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг өнөөдөр зохион байгууллаа. Санхүүгийн зохицуулах хорооны “Санхүүгийн хүртээмж” танхимд зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн болон өөрийгөө зохицуулах байгууллага, үнэт цаасны компани, арилжааны банкнуудын холбогдох төлөөллүүд оролцов.

УИХ-аас баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо дээрх журмыг баталснаар мөнгөний зах зээлийн бүтээгдэхүүн болох хадгаламжийн сертификатыг биржийн болон биржийн бус зах зээлд арилжихтай холбоотой эрх зүйн зохицуулалтын орчин бүрдэж, хөрөнгийн зах зээлд санхүүгийн шинэ бүтээгдэхүүн нэгээр нэмэгдсэн. Харин

цаашид хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн болон өөрийгөө зохицуулах байгууллагууд нь өөрийн холбогдох дүрэм, журамдаа өөрчлөлт оруулж, Хороогоор батламжлуулах ажлыг зохион байгуулах юм. Үнэт цаасны зах зээлд энэхүү бүтээгдэхүүнийг арилжаалж эхэлснээр хөрөнгийн зах зээл дээр арилжаалдаг, хөрвөх чадвар сайтай хадгаламжийн сертификат бий болж, банкны салбараас эх үүсвэр гэнэт татагдах эрсдэл багасах, иргэд, хадгаламж эзэмшигчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран банкаа сонгох, хадгаламжаа хоёрдогч зах дээр арилжаалах боломжтой болох зэрэг ач холбогдолтой.

## ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ ШИНЭЧЛЭГДЛЭЭ

“Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам” болон ипотекийн зээлийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох бусад журамд ипотекийн зээлдэгч нь амь нас, эрүүл мэндийн болон барьцаа хөрөнгийн даатгалд зээлийн үүргийн гүйцэтгэл дуусах хүртэлх хугацаанд заавал даатгуулах шаардлага тавигдсан байдаг. Гэтэл практик дээр ипотекийн зээлдэгч нар нь зөвхөн гэнэтийн ослын эрсдэлийг сонгон даатгуулах, үүний улмаас нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалтад нөлөөлөх голлох өвчний эрсдэлүүд даатгагдахгүй байх, мөн зээлийн гэрээний үргэлжлэх хугацаанд даатгалын гэрээний сунгалт хийгдэхгүйгээс даатгалын хамгаалалтгүй болох нөхцөл байдал үүсэж зээлдэгч, эсхүл гэр бүлийн гишүүдэд өндөр дүнтэй зээл төлөх санхүүгийн дарамт учрах зэрэг нэлээдгүй асуудал үүсэж байна. Иймд үүнийг шийдвэрлэх, зохицуулалтыг олон улсын сайн жишигт нийцүүлэх зорилгоор “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д ипотекийн даатгалын үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой өөрчлөлтийг орууллаа. Ингэснээр зээлдэгч нь барьцаа хөрөнгөө ердийн даатгалын компаниудад даатгуулах харин зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хувьд зөвхөн урт хугацааны даатгагчийн санал болгож буй бүтээгдэхүүнд хамрагдахаар боллоо.

Даатгалын багц дүрэмд тусгагдсан ипотекийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой энэхүү шинэчилсэн зохицуулалт хэрэгжиж эхэлснээр даатгалын хамгаалалтын хэмжээ 5-6 дахин нэмэгдэж, даатгуулагчаас гадна түүний гэр бүл дээрх эрсдэлийн улмаас санхүүгийн хүндрэлд орох, орон байраа алдах зэргээс бүрэн хамгаалагдах боломжтой болно. Мөн даатгалын гэрээг жил бүр сунгах шаардлагагүй болсноор оролцогч талуудад цаг хугацаа, зардлын хэмнэлт бий болох, ипотекийн даатгалтай холбоотой аливаа маргааны тоо буурах цаашилбал даатгуулагчдын эрх ашиг хамгаалагдах ач



холбогдолтойгоос гадна урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох замаар ипотекийн зээлийн эко системд эерэг нөлөөг үзүүлэх давуу талтай.

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ДЭЭД ХЭМЖЭЭГ ДАХИН ТОГТООЛОО

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ээлжит хуралдаан боллоо. Хуралдаанаар мөнгөн зээлийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, статистик тоо баримт болон эрх зүйн орчны зохицуулалт, гаднын сайн туршлага, зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоосон улс орнуудын харьцуулсан судалгаа зэрэг мэдээлэлтэй танилцаж, энэ сарын 12-нд зохион байгуулсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа дахь зээлийн хүүгийн дээд хэмжээ” хэлэлцүүлгээс гарсан санал дүгнэлтийг хэлэлцлээ. Мөн Улсын дээд шүүхийн өнгөрсөн оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн тогтоолоор Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс дахин шинэ акт гаргах хүртэл тус зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох тухай” 01 дүгээр тогтоолыг зургаан сарын хугацаагаар түдгэлзүүлсэнтэй холбогдуулан энэ хуралдаанаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд


хэмжээг сарын 4.5 хувь хэвээр үлдээх шийдвэрийг гаргалаа.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд хуульд мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, зохицуулах, холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд байгуулахаар хуульчилсан. Зөвлөл Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага, цагдаагийн төв байгууллага, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид болон салбарын эрдэмтэн, судлаачдын төлөөллөөс бүрддэг бөгөөд үндсэн чиг үүрэг нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загвар, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг батлахад оршдог.



## ЯРИЛЦЛАГА

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАРЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



*Хадгаламж, зээлийн хоршооны газрын референт  
К.Булбултай ярилцлаа.*

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, ногоон санхүүжилтийг илүү хүртээмжтэй хүргэхэд тохиромжтой санхүүгийн байгууллага юм.

Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд хоршоодын оруулах хувь нэмрийг үнэлж өнгөрсөн жил Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 78 дугаар чуулганы 06 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар ногоон ирээдүйг дэмжихээр 2025 оныг “Олон улсын хоршооллын жил” болгон зарласан. “Хоршоод дэлхийн сайн сайхны төлөө” уриа дор хоршооллын хөдөлгөөний томоохон байгууллагууд олон төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

#### **Манай улсын ХЗХ-ны салбарын ногоон санхүүжилт ямар түвшинд байгаа вэ?**

Ногоон санхүүжилт сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж санхүүгийн салбарт нийтлэг болоод байгаа ч ХЗХ-ны салбарт харьцангуй сул байна.

Санхүүгийн зохицуулах хороо Азийн хөгжлийн банктэй хамтран 2022 оноос эхлэн “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азид жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд ХЗХ-ны жендерийн мэдрэмжтэй ногоон санхүүгийн өнөөгийн байдал, ХЗХ-ны гишүүн эмэгтэй удирдлага бүхий бичил болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээний талаар суурь судалгаа хийсэн. “Ногоон” төслүүд, тэр дундаа ХЗХ-ны ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд ХЗХ-дод тулгарч буй саад бэрхшээл, боломжит хөшүүргийг үнэлж тодорхойлсон. Байгальд ээлтэй ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээл/сорилтуудыг: (1) хөнгөлөлттэй санхүүжилт байхгүй, (2) мэдээлэл дутмаг эсвэл байхгүй, (3) цаг агаар,

**Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт үзэгдэл ихээр тохиолдох болсонтой холбогдуулан улс орнууд дэлхий нийтийг хамарсан санаачилга, хэлэлцээрүүдийг хийж, Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд санхүүгийн салбарын үүрэг оролцоо чухал болохыг онцолж байна. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх)–дын оруулах хувь нэмрийг та юу гэж харж байна вэ?**

Монголын банкны салбараас эхэлсэн тогтвортой санхүүжилт болон байгальд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ сүүлийн жилүүдэд санхүүгийн бусад байгууллагуудаар хүрээгээ тэлж байна. ХЗХ-ны салбар иргэн төвтэй, нийгэм рүү чиглэсэн ашгийн бус үйл ажиллагаа эрхэлдгээрээ бусад санхүүгийн салбараас ялгаатай байдаг. Гишүүдийн хэрэгцээ болон боломжийг илүү олж харж чаддаг тул нийгмийн хариуцлагын хүрээнд ногоон санхүүжилтээр дамжуулан

<sup>1</sup> Lloyd's – Андеррайтерийн чиг үүрэг бүхий хувь хүн, хуулийн этгээдийн нэгдэл. Нэг болон түүнээс дээш синдикатуудын гишүүний хувьд эрсдэлийг даатгах, давхар даатгах үйл ажиллагаа явуулдаг. Ллойдс нь даатгалын компани бус зах зээл юм. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, 2024 он)

улирлын таатай бус байдал, (4) ажиллах хүч дутмаг гэсэн дарааллаар ХЗХ–д хамгийн их хариулт ирүүлснээс ХЗХ чөлөөт мөнгөн хөрөнгийн дутагдалтай, эх үүсвэр хангалтгүй ба санхүүжилт авах мэдээллийн суваг бага, улирлын чанартай хөдөө аж ахуйн салбарт ажилладаг гэсэн дүгнэлт гарсан.

Мөн байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тойрог эдийн засгийн загвар хөгжүүлэх талаар сурталчлан таниулах үйл ажиллагааг нэмэгдүүлбэл урт хугацаанд бараа бүтээгдэхүүнийг дахин эргэлтэд оруулж, хог хаягдлын хэмжээг бууруулах хэрэгцээ, сонирхол ХЗХ–ны гишүүдийн дунд өндөр байгаа нь харагдаж байна.

### **Эдгээр асуудлуудыг хэрхэн шийдэх вэ?**

Тулгарч буй саад бэрхшээлүүд байгаа ч ХЗХ–д өөрсдийн эх үүсвэрийн хүрээнд боломжоороо ногоон зээлийг гишүүддээ хүргэхээр ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны 2 дугаар улирлаас ногоон зээлийн судалгааны тайланг ХЗХ–доос авч эхэлсэн. 2030 он гэхэд банкнууд зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хувийг 10%, банкнаас бусад салбар 5%–д хүргэхээр зорьж байна. ХЗХ–д ч мөн энэ түвшинд хүргэхийг зорино.

Төслийн хүрээнд “Жендерийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтийн чиглэлээр сургагч багш бэлтгэх” сургалтыг зохион байгуулж, уг сургалтад СЗХ–ны албан хаагчид болон МХЗХҮХ–ны сургагч багш нарыг хамруулсан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос ХЗХ–дын удирдах албан тушаалтнуудад ногоон санхүүжилтийг сурталчлах, таниулах, зээлийг хэрхэн ангилах талаар сургалтыг МХЗХҮХ–той хамтран давтамжтай зохион байгуулж, ногоон санхүүжилтийн талаар мэдлэгийг түгээж байна.

Түүнчлэн, ХЗХ–д болон сургагч багш нарт зориулсан гарын авлагыг бэлдэж байна. ХЗХ–ны санхүүжилтийн тогтвортой байдалд нөлөөлөх уур амьсгалын эрсдэлт хүчин зүйлийн нөлөө өндөр байдаг тул бага гэлтгүй нэмэр болгох үүднээс ХЗХ–дын гишүүдэд анхан шатны мэдлэг олгох, цаашид амьдралын хэв маягтаа хэвшүүлж болох Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU)–ноос бэлтгэн гаргасан “Хадгаламж, зээлийн хоршоод уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн дасан зохицож, хувь нэмрээ оруулах талаарх зөвлөмж”–ийг орчуулан уг гарын авлагад оруулж байна. Энэхүү гарын авлагад жендерийн тэгш байдал, санхүүгийн хүртээмж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

бодлого, арга хэмжээний хэрэгжилтийн талаар цогц мэдээллийг багтаана.

### **Гаднын улс орнуудын ХЗХ–дын ногоон санхүүжилт ямар түвшинд байгаа бол?**

Гадаад орны олон туршлага байна. Жишээлбэл, Энэтхэг улс байгаль орчинд ээлтэй төслүүдийг санхүүжүүлэхэд зориулан богино болон дунд хугацааны санхүүжилтийг хөдөө аж ахуйн хадгаламж, зээлийн хоршоо (Green Banking and Agricultural credit cooperatives)–доор дамжуулан хөдөө аж ахуй эрхлэгчдэд олгож байна.

Европт ХЗХ–доор дамжуулан сэргээгдэх эрчим хүч, органик хүнс, барилга байгууламжийн төслүүдэд дунд хугацааны хөрөнгө оруулалтын санхүүжилтүүдийг олгодог.

Америкийн Нэгдсэн Улсын Ногоон санхүүжилтийн хүртээмжийн байгууллагын Хүлэмжийн хийг бууруулах сангаас ХЗХ–доор дамжуулан орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих, бага орлоготой болон эмзэг бүлгийн иргэдэд ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хүргэхээр санхүүжилт олгодог. Нийт 1.8 тэрбум ам.долларын санхүүжилтийг 300 гаруй ХЗХ–оор дамжуулан ногоон төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болгох үүднээс олгосон байна.

Канад улсад гэхэд бага орлоготой болон эмзэг бүлгийн иргэдэд нарны эрчим хүчний систем, эрчим хүчний хэмнэлттэй байшин барих зэрэг төслүүдэд ХЗХ–д ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож дэмждэг гэх мэтчилэн олон орнуудыг дурдаж болно.

### **Цаашид салбарт ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?**

Манай улсын хувьд донор байгууллагуудаас ногоон санхүүжилтийн төслүүдийг банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан түгээж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос цаашид Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг, Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоотой хамтран ХЗХ–дын бичил болон жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнийг бий болгох, ХЗХ–дын гишүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгахад хувь нэмэр оруулах ногоон санхүүжилтийн ашиг тусыг таниулах, сурталчлах, орон нутгийг хөгжүүлэх сангуудтай хамтран ажиллах боломжуудыг эрэлхийлж байна.

### **Ярилцсанд баярлалаа, цаашдын ажилд нь амжилт хүсье.**

# ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТ

Эхлэл нь 1-р нүүрт

Цаашлаад дээрх бизнес эрхлэгчдийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжвэл эдийн засгийн эргэлтэд буй бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэхийн сацуу ажлын байрны хүртээмж нэмэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг болох, эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмэр, үүрэг дээшлэх зэргээр манай улсын эдийн засагт олон эерэг нөлөө гарна. Түүнчлэн, гадаадын болон Монгол Улсын иргэн, хуулийн этгээдүүд хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд оролцон хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах, санхүүжилт татан төвлөрүүлж буй компанийн хувьцаа эзэмшигч болох, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох, өгөөж хүртэх боломжтой болно.

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХААР ГАРГАХ ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГЭХ, АРИЛЖИХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

#### 1. Журмын бүтэц, зохицуулах харилцаа

Тус журам нь 6 бүлэг, 4 хавсралтаас бүрдэх бөгөөд үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд бүртгэх, биржийн болон биржийн бус зах зээлд арилжихаар гаргах, тайлагнах, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулна. Харин энэ журмын зохицуулалтад хадгаламжийн сертификатыг мөнгөний зах зээлд гаргах, арилжихтай холбоотой харилцаа хамаарахгүй.

Банк нь биржийн болон биржийн бус зах зээлд гаргаж буй хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллага, Холбоонд нэгэн зэрэг гаргаж болно.

Дараах шаардлагыг хангасан банк хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээл /биржийн болон биржийн бус зах зээл/-д арилжихаар гаргана:

Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн хоёр жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;

Банкны тухай хууль тогтоомж болон Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг сүүлийн нэг жилийн хугацаанд бүрэн хангасан байх;

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангасан байх.

#### 2. Гарах үр дүн

Уг журам хэрэгжсэнээр хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг, хөрвөх чадвар сайтай хадгаламжийн сертификат бий болж, банкны салбараас эх үүсвэр гэнэт татагдах эрсдэл багасах, иргэд, хадгаламж эзэмшигчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран банкаа сонгох, хадгаламжаа хоёрдогч зах дээр арилжаалах зэрэг эерэг үр дүн гарах хүлээлттэй байна.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

### Буцалтгүй тусламж, урт хугацааны санхүүжилт

Сэргээгдэх эрчим хүчний технологийг (СЭХТ) төслийн хөрөнгө оруулалтын зардлын тодорхой хэсгийг санхүүжүүлдэг. Энэ нь ихэвчлэн төслийн эцсийн санхүүгийн зардлыг бууруулж, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, эсвэл эрчим хүчний худалдан авагч талууд бүтээгдэхүүнийг нь заавал худалдаж авах үүрэг хүлээсэн тохиолдолд хэрэглэгчдэд нийлүүлэх үнийг бууруулах зорилготой байдаг. Энгийн грантууд /Буцалтгүй зээл/ нь төсөлд хяналт тавих механизмыг бий болгодоггүй бөгөөд төслийг хэрэгжүүлэгчийг тогтвортой, ашигтай төсөл боловсруулах урамшуулал өгдөггүй. Харин зээлтэй харьцуулахад, зээлийн нөхцөлөөр төслийг тодорхой хэмжээгээр орлого олж, эргэн төлөлт хийх шаардлагатай болдог. Гэсэн хэдий ч грант нь төслийн зардлыг бууруулж, хүртээмжтэй болгоход зайлшгүй шаардлагатай байж болно. Үүнээс гадна, грантыг хэрэгжүүлэх, удирдах явц нь харьцангуй энгийн байдаг. Учир нь, зээлийн эргэн төлөлтийн чадамжийг судлах буюу нарийн шалгалт хийх, зээлийн удирдлагыг тасралтгүй хянах шаардлагагүй.

#### Ашиглах зорилго

- ◆ Төслийн зардлыг бууруулах, урт хугацааны санхүүжилтээр хангах.

#### Давуу тал

- ◆ Хэрэгжүүлэхэд харьцангуй хялбар.
- ◆ Тогтмол удирдлага, хяналт шаарддаггүй.

#### Сул тал

- ◆ Төслийн зорилгод хүрэх эрсдэл өндөр, учир нь хэрэгжүүлэгчдийг урамшуулах механизм байхгүй.
- ◆ Буцалтгүй тусламжийг хөрөнгө оруулалтын хувьцааны хэлбэрээр олговол, төрийн байгууллага төслийн удирдлагад оролцож, гүйцэтгэлийн явц удаашрах, хувийн санхүүжилтийг шахах эрсдэлтэй.
- ◆ Хөшүүргийн түвшин бага, учир нь энэ нь шууд хувийн санхүүжилтийн орон зайг эзэлдэг.

### Венчур капитал

СЭХТ өргөжүүлэхэд төрийн эх үүсвэрээс хийгдэх өмчийн хөрөнгө оруулалт нь урт хугацааны хөрөнгө оруулалт болон венчур капиталын санхүүжилт гэсэн хоёр хэлбэртэй байж болно. Венчур капиталын санхүүжилт нь өндөр эрсдэлтэй төслүүдийг хөгжүүлэх зорилготой бөгөөд тодорхой хугацааны дараа хөрөнгө оруулалтаас гарах стратегитай байдаг.

Венчур капиталын санхүүжилтийн онцлог нь шинэ технологи, өндөр өсөлттэй компаниудад чиглэдэг. Хөрөнгө оруулагчид хувьцаагаа хөрөнгийн зах зээл дээр IPO хийх эсвэл томоохон компаниудад зарах замаар ашгаа хүртэхийг зорьдог ба энэ төрлийн санхүүжилт нь өндөр эрсдэлтэй тул хөрөнгө оруулагчид өндөр өгөөжийг шаарддаг.

#### СЭХТ–д үзүүлэх нөлөө

- ◆ Санхүүгийн систем хөгжөөгүй бол венчур капиталын санхүүжилт үр дүнгүй байх магадлалтай.
- ◆ Бага орлоготой орнуудад венчур санхүүжилт тохиромжгүй байдаг. Тиймээс олон улсын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц инновацлаг технологи ашиглавал боломжтой.

**Ашиглах зорилго**

- ◆ Урьдчилсан хөрөнгө оруулалтын зардлыг өндөр эрсдэлтэй капиталын хэлбэрээр санхүүжүүлэх.

**Давуу тал**

- ◆ Өөрийгөө санхүүжүүлдэг – хөрөнгө оруулалтын өгөөжөөс өөрийгөө нөхөх боломжтой.

**Сул тал**

- ◆ Өндөр өгөөж шаардагдана – Эрсдэл өндөр тул хөрөнгө оруулагчид өндөр ашиг хүлээдэг. Төрийн санхүүжилт хувийн хөрөнгө оруулагчдаас бага өгөөж хүлээн зөвшөөрөх боломжтой тул энэ нь хувийн секторын өрсөлдөх чадварыг бууруулж болзошгүй.
- ◆ Хөшүүргийн түвшин бага – Хувийн санхүүжилтийг шууд орлох тул нэмэлт хөрөнгө татах чадвар сул.

**Өр төлбөр**

Сэргээгдэх эрчим хүчний технологийн төслүүдэд олгож буй зээлийг илэрхийлнэ. Олон нийтийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн давуу эрхтэй өр нь төслийн зээл эсвэл зээлийн шугамын хэлбэрээр олгогдоно. Төслийн орлогоос эхний ээлжинд төлөгдөх өр

**Ашиглах зорилго:**

- ◆ Төслийн зардлыг бууруулах ;
- ◆ Урт хугацааны санхүүжилт олгох ;
- ◆ Хувийн секторын хөрөнгө оруулалтыг татах ;
- ◆ Төсөлд тохируулан зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уян хатан зохицуулах ;

**Давуу тал**

- ◆ Зээлийг төлөх үүрэгтэй учир төсөл амжилттай хэрэгжих урамшуулал бий болгодог.
- ◆ Үндсэн төлбөрийг буцаан төлснөөр дараагийн сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгийг чөлөөлнө.

**Сул тал**

- ◆ Зээлийг эргэн төлөх чадварыг баталгаажуулах нарийвчилсан судалгаа шаардлагатай тул гүйлгээний зардлыг нэмэгдүүлдэг.
- ◆ Хөшүүргийн түвшин хязгаарлагдмал байх бөгөөд хувийн хэвшлийн боломжит зээл олгогчдыг шахах эрсдэлтэй.

**Жижиг хэмжээний төслийн санхүүжилт**

Энэ төрлийн санхүүгийн хэрэгслүүд нь жижиг хэмжээний сэргээгдэх эрчим хүчний төслүүд (RET), гэр ахуйн болон орон нутгийн түвшинд сүлжээнээс тусгаарлагдсан цахилгаанжуулалтын системүүдэд зориулагдсан.

**Микро санхүүжилт (Microfinancing)**

Микро санхүүжилтийн байгууллагуудаар (MFI) дамжуулан санхүүжилтийг олгох нь нэгэн шийдэл байж болно. Энэ арга нь айл өрхүүдэд шууд зээл олгох эсвэл тоног төхөөрөмж нийлүүлэгчид дамжуулан зээл олгож, тэдгээр нь сэргээгдэх эрчим хүчний системийн анхны хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг санхүүжүүлэх боломжтой болгодог.

### Давуу тал

- ◆ Зээлийн эргэн төлөлт хийгдэх шаардлага нь нийлүүлэгчдийн тогтолцоог хэвийн ажиллуулах, засвар үйлчилгээ үзүүлэх урамшуулал өгдөг.
- ◆ MFI-ууд нь жижиг бизнес, өрхийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн үйл ажиллагааг дэмжих зорилготой байдаг тул ийм төслүүдэд анхаарал хандуулах боломжтой.
- ◆ Микро зээлийг өндөр хүүтэй, богино хугацаатай олгодог тул MFI-ууд шинэ санхүүжилтийн загварыг турших боломжтой.

### Хязгаарлалт ба шийдэл

- ◆ Гэр ахуйн нарны систем (SHS) гэх мэт урт хугацааны төлбөрийг шаарддаг хэрэглээний зээл нь уламжлалт MFI загварт тохирохгүй байж магадгүй.
- ◆ Бангладеш улсад үр дүнд суурилсан санхүүжилт (RBF) болон микро санхүүжилтийг хослуулж, MFI-уудыг зээлийн хөрөнгийг дахин санхүүжүүлэх боломжтой болгосон.

### Төрийн санхүүжилтийн боломжууд

- ◆ Зээлийн шугам (credit line) гаргах – MFI-д хүртээмжтэй санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн зээлийн өртгийг бууруулах.
- ◆ Татаас, буцалтгүй тусламж олгох – RBF загварын дагуу олгож, тодорхой суурилуулалт хийсний дараа баталгаажуулан санхүүжүүлэх.
- ◆ Баталгааны механизм ашиглах – Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд MFI-уудын алдагдлыг тодорхой хэмжээгээр нөхөх.

Эдгээр механизмууд нь жижиг хэмжээний сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг дэмжих, хөрөнгө оруулалтын бэрхшээлийг бууруулах үр дүнтэй арга болж чадна.



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## ТУЗ-ИЙН 2025 ОНД АНХААРАХ 5 СОРИЛТ

Судалгаа үргэлжлэл...

### Сорилт 2: Нийгэм, улс төрийн асуудалд – оролцох, эс оролцох

Өнөөгийн бизнесийн нөхцөлд ТУЗ гүйцэтгэх удирдлага болон компанид нийгэм, улс төрийн асуудалд хэзээ, хэрхэн оролцох талаар ямар чиглэл өгөх ёстой вэ? Орчин үеийн бизнесийн үүрэг хариуцлагын талаар нийгмийн хүлээлт өргөжиж байгаатай холбоотойгоор компаниуд өөрсдийн байр суурийг нийгэмд эерэг өөрчлөлт авчрахад ашиглахыг хүссэн оролцогч талуудын шахалттай тулгарч байна. Түүнчлэн, үндсэн үйл ажиллагаанаас гадуурх асуудлуудад оролцох хүлээлт ч энд багтана.

Мэдээ, мэдээллийн гарчгууд компанийн гаргасан алдаа, сорилтуудыг онцолж, оролцогч талуудын (ихэвчлэн зөрчилтэй) хүлээлтийг хангах нь хүндрэлтэй байгааг харуулсаар байна. Ихэнх компани олон нийтийн маргаантай асуудалд оролцохдоо болгоомжтой хандах болсон төдийгүй зарим нь өмнөх амлалтуудаа өөрчилж, бүрэн зогсоох шийдвэр гаргажээ. Тухайлбал, компаниуд олон нийтийн анхаарал татахуйц бие даасан хөтөлбөрүүдээс илүүтэйгээр олон талт, тэгш байдал, хамруулан оролцуулах (DE&I) санаачилгуудыг стратегидаа нэгтгэн ажиллаж байна.

Энэ нь корпорацуудын үүрэг хариуцлагын талаарх олон нийтийн хандлага өөрчлөгдсөнийг харуулж байгаа бөгөөд Gallup-ийн хийсэн судалгаагаар, Америкчуудын 38 хувь нь бизнес эрхлэгчид нийгмийн тулгамдсан асуудалд байр сууриа ил тод илэрхийлэх ёстой гэж үзэх нь 2022 онтой харьцуулахад 10 хувиар буурсан байна.

Оролцогч талуудын үзэл бодол өөрчлөгдөж, компанийн нэр хүндэд учирч болох эрсдэл нэмэгдэж байгаа нөхцөлд, ТУЗ компанийн байр суурь, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй. NACD-ийн 2025 оны чиг хандлага, тэргүүлэх чиглэлийн судалгааны мэдээллээс харахад оролцогчдын дөрөвний нэг нь (27%) гүйцэтгэх удирдлага болон удирдлагын багт олон нийтийн асуудлаар зөвлөгөө өгсөн гэж хариулжээ. Тэдгээрээс гуравны нэг (33%) нь компанийн стратеги болон гол оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн асуудалд идэвхтэй оролцохыг уриалсан бол, 28 хувь нь төвийг сахисан, маргаанаас холуур байх зааварчилгааг өгчээ.

### Анхаарах зүйлс

Оролцогч талуудын үзэл бодол өөрчлөгдөж буй энэхүү нөхцөлд ТУЗ компанийн нэр хүндэд учирч болзошгүй эрсдэлийг харгалзан үйл ажиллагааг чиглүүлэх үүрэгтэй.

- ◆ Удирдлагын баг болон ТУЗ урьдчилан бэлтгэсэн шийдвэр гаргах тогтолцоотой байх –Компани нийгэм, улс төрийн асуудалд хэзээ, хэрхэн оролцох, ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг, шийдвэр гаргах тогтолцоог нарийн тодорхойлох хэрэгтэй. Энэ хандлага нь эрхэм зорилго, стратегитай уялдсан байх хэрэгтэй.
- ◆ Оролцогч талуудын үзэл бодлыг ойлгох – Удирдлагын баг болон ТУЗ нь хэрэглэгчид, ажилтнууд, хөрөнгө оруулагчид болон улс төрийн орчинд үйл ажиллагаа явуулж буй бусад талуудтай идэвхтэй харилцаж, тэдний хүлээлт, үнэт зүйлсийг тодорхойлох хэрэгтэй. Ингэснээр богино болон урт хугацаанд гарч болзошгүй нийгэм, улс төрийн байр суурь, үр дагаврыг урьдчилан таамаглах боломжтой.
- ◆ Гүйцэтгэх удирдлага болон удирдлагын баг нийгмийн асуудалд оролцохдоо учирч болзошгүй эрсдэлүүдийг урьдчилан үнэлэх – NACD-ийн гүйцэтгэх удирдлагын идэвхжилтийн талаарх зөвлөмжид дурдсанаар, удирдлагын баг нийгэм, улс төрийн асуудалд хөндлөнгөөс оролцохдоо санхүүгийн болон нэр хүндийн эрсдэлийг тооцоолох ёстой. Үүнд компанийн эрсдэлийн удирдлагын (ERM) хүрээнд эрсдэлийн ач холбогдлыг үнэлэх, боломжит сөрөг үр дагавар, санамсаргүй нөхцөл байдалд компани хэрхэн хариу үйлдэл үзүүлэх талаар авч үзэх шаардлагатай.
- ◆ ТУЗ-ийн оролцооны цар хүрээ, хугацааг зөв тодорхойлох – Зарим нарийн төвөгтэй асуудлын хувьд ТУЗ-ийн идэвхтэй оролцоог шаарддаг бөгөөд энэ нь захирлуудын мэргэжлийн ур чадвар, өмнө нь ижил төстэй асуудалтай ажиллаж байсан туршлага, хяналтын үүрэг хариуцлагаас шалтгаалан ТУЗ-ийн оролцоог оновчтой үнэлэх нь чухал.

### Сорилт 3: Богино хугацааны үйл явдалд урт хугацааны стратеги хэрэгжүүлэх

Бизнесийн төлөвлөлтийн хугацаа богиносож байна. Судалгаанд оролцсон захирлуудын тал орчим хувь нь (46%) өнөөгийн бизнесийн орчинд урт хугацааны өсөлтийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх нь "маш" эсвэл "онцгой" хэцүү байгааг тэмдэглэжээ. Үүнээс гадна, 70 орчим хувь нь урт хугацааны өсөлтийн төлөвлөгөө боловсруулж, тогтвортой хэрэгжүүлэх нь таван жилийн өмнөхтэй харьцуулахад илүү хүндрэлтэй болсон гэж хариулсан байна.

Түүнчлэн "урт хугацааны" стратеги төлөвлөлтийн ойлголт өөрчлөгдөж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 17 орчим хувь нь таван жил болон түүнээс дээш хугацаагаар стратегийг тодорхойлсон бол 70 хувь нь 3–5 жилийн хугацаатай төлөвлөгөө боловсруулсан гэжээ. Харин олон нийтэд хувьцаагаа арилжиж буй нээлттэй компаниуд урт хугацааны стратеги төлөвлөлтөд 3 жил буюу түүнээс бага хугацааг тогтоох хандлага нэмэгдэж, 2022 онд 9 хувь, 2024 онд 13 хувь болж өссөн байна.

Мөн судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (56%) нь "эдийн засгийн тогтворгүй байдал"-ыг богино хугацааны дарамтын хамгийн чухал эх үүсвэр гэж үзсэн бол 36 хувь нь "технологийн хөгжил"-ийг онцолсон. Нийт оролцогчдын ойролцоогоор гуравны нэг (32%), олон нийтэд хувьцаагаа арилжиж буй нээлттэй компаниудын төлөөлөгчдийн 41 хувь нь "хөрөнгийн зах зээл болон хөрөнгө оруулагчдын хүлээлт"-ийг гол дарамтын хүчин зүйл гэж хариулжээ. Зарим тохиолдолд богино хугацааны дарамт бодит бус хүлээлтээс үүдэлтэй байж болно. Жишээлбэл, өнгөрсөн жилийн NACD ТУЗ-ийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийн судалгаагаар хөрөнгө оруулагчид "урт хугацааны стратегийн хяналт" нь хамгийн түгээмэл хөндөгдсөн асуудлуудын нэг байсныг онцолжээ. Компани бүр өөрийн гэсэн хөрөнгө оруулагч баазтай ч "Бид өөрсдөө энэ дарамтыг бий болгож байна уу" гэсэн асуулыг тавьж үзэх нь зүйтэй. Хачирхалтай нь, 2025 оны судалгаанд оролцогчдын 47 хувь нь ТУЗ өөрөө богино хугацааны дарамтын эх үүсвэр болсон гэдэгтэй санал нэгдэжээ.

#### Анхаарах зүйлс

- ◆ ТУЗ нь богино хугацааны дарамт, шахалтын үед урт хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах хэд хэдэн арга хэмжээг авах боломжтой.
- ◆ ТУЗ нь компанийн урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа хэрэгжүүлэх, бүх оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох үүрэг хариуцлагыг

хэрхэн биелүүлж байгаад анхаарал хандуулах хэрэгтэй. "Америкийн ТУЗ-ын ирээдүй" тайланд онцлон тэмдэглэснээр, үр дүнтэй ТУЗ нь удирдлагын багийг урт хугацааны чухал зорилтуудад төвлөрөхийг чиглүүлэн урамшуулж, нэгэн төрлийн тэнцвэржүүлэгч болж ажилладаг. Ингэснээр богино хугацааны төлөвлөгөөнүүд өөрчлөгдөж байсан ч бизнест чухал ач холбогдолтой урт хугацааны зорилгод анхаарлаа төвлөрүүлэхэд туслах үүрэг гүйцэтгэдэг гэжээ.

- ◆ Ихэнх байгууллага уламжлалт, урт хугацааны төлөвлөлтөөс татгалзаж, тасралтгүй стратеги төлөвлөлтийн арга барил руу шилжиж байгаа бөгөөд энэ нь стратегийн янз бүрийн хувилбаруудыг тогтмол судалж, туршиж үзэх шаардлагатай болдог. Түүнчлэн, ТУЗ хувилбаруудыг ашиглаж, төлөвлөлтийг боловсруулахад удирдлагыг уриалах хэрэгтэй. Ийнхүү хувилбар, таамаглалыг шалган, туршиж үзсэнээр ТУЗ шаардлагатай үед зохицуулалт хийхэд бэлэн байхаас гадна урт хугацааны зорилгодоо төвлөрч чадна.
- ◆ ТУЗ нь улирлын тайлангийн зөвлөмж гаргахаас татгалзахыг санал болгох хэрэгтэй, учир нь богино хугацааны гүйцэтгэлийн үр дүнд хэт их ач холбогдол өгөх хандлагыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. FCLTGlobal-аас хийсэн судалгаагаар улирал тутам хувьцаанд ногдох ашгийн (EPS) тайлан гаргах хэвшил сүүлийн жилүүдэд эрс багассан болохыг харуулж байна. Тодруулбал, 2024 онд S&P 500-д багтдаг компаниудын дөнгөж 19 хувь нь энэхүү зөвлөмжийг гаргаж байгаа нь 2010 онд 36 хувь байсан үзүүлэлттэй харьцуулахад мэдэгдэхүйц буурсан байна.

*Үргэлжлэл бий..*

## ФИНТЕК БА РЕГТЕК

### ШИЛДЭГ 10: ГАР УТСАНД СУУРИЛСАН МӨНГӨНИЙ ПЛАТФОРМУУД

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ Африк болон Азийн хэмжээнд санхүүгийн салбарын хүртээмжийг нэмэгдүүлж буй шилдэг 10 гар утсанд суурилсан мөнгөний платформуудыг танилцуулахаар бэлтгэлээ. Эдгээр платформ нь хөгжиж буй эдийн засагтай орнуудад санхүүгийн үйлчилгээнд хувьсгал хийж уламжлалт банкны системд хамрагдах боломжгүй тэрбум гаруй хүнд банкны үйлчилгээг хүргэж байна. Ухаалаг утсанд суурилсан эдгээр төлбөрийн экосистем нь энгийн шилжүүлгээс эхлээд нарийн төвөгтэй санхүүгийн үйлчилгээг ч гүйцэтгэх боломжтой бөгөөд банкны салбар, дэд бүтцийн шаардлагагүйгээр ажилладаг юм. Энэхүү мэдээллийг Fintech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.

#### 10. TRUEMONEY

Тайланд Улсын “True” корпорацаас хөгжүүлсэн TrueMoney нь Зүүн Өмнөд Азийн бүс нутагт нөлөө бүхий гар утасны төлбөрийн үйлчилгээ болж чаджээ. Энэхүү платформ нь өдөр тутмын хэрэгцээт төлбөрүүд болох хэрэглээний төлбөр, онлайн худалдан авалт, мөнгө шилжүүлэх зэрэг гүйлгээг энгийн, ойлгомжтой аппликейшнээр дамжуулан гүйцэтгэдэг. Цахим үйлчилгээний хажуугаар биечлэн үйлчлэх боломжтой салбаруудтай учир TrueMoney нь технологийн хэрэглээнд дасаагүй хүмүүсээс эхлээд дэвшилтэт технологи хэрэглэгчдэд хүртэл хүрч ажилладаг. Анх Тайландад төвлөрч эхэлсэн энэ үйлчилгээ нь одоо Зүүн Өмнөд Азийн хэд хэдэн улсад өргөжиж, тухайн бүс нутгийн онцлог, санхүүгийн хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээгээ тохируулж байгаа ч үндсэн үйл ажиллагааны хэв маягаа хадгалсаар байна.

#### 9. WAVE

Wave нь баруун Африкийн гар утасны мөнгөний зах зээлд өөрийн бие даасан, бага шимтгэлтэй загвараар орж ирснээр харилцаа холбооны компаниудад тулгуурласан уламжлалт үйлчилгээний загварт сорилт болсон юм. Сенегал, Кот-д’Ивуар зэрэг улсуудад эхлэн нэвтэрсэн энэ үйлчилгээ нь харилцаа холбооны операторуудаас хамааралгүйгээр зөвхөн Android ухаалаг утсанд зориулсан QR код бүхий аппликейшн ашиглан ажилладаг. Wave нь ихэнх хэрэглэгч хоорондын (peer-to-peer) мөнгөн шилжүүлэгт шимтгэл авдгаа зогссон нь, өрсөлдөгч компаниудыг үнэ тарифын бодлогоо эргэн харахад хүргэсэн. Мөн тус платформ нь олон төрлийн хэрэглээ бүхий дэлгүүрүүдийн оронд зөвхөн Wave-д зориулсан цэнхэр киоскуудаар дамжуулан агентын сүлжээг ажиллуулж үйл

ажиллагааныхаа хүрээнд хэрэглэгчдэд ижил, нэг стандартаар үйлчлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

#### 8. JIO PAYMENTS BANK

Reliance Jio компанийн санхүүгийн платформ нь өрсөлдөөнтэй Энэтхэгийн дижитал төлбөрийн салбарт гарч ирсэн бөгөөд Jio-гийн харилцаа холбооны экосистемтэй уялдан байдлаараа онцлог юм. Энэ үйлчилгээ нь Энэтхэгийн Unified Payments Interface (UPI)-ийг ашигладаг бөгөөд Reliance-ийн жижиглэн худалдааны сүлжээнд суурилсан өвөрмөц боломжуудыг санал болгодог. Jio Payments Bank нь стратегийн хувьд орон нутгийн хэрэглэгчдийг зорилтот бүлэг болгож, анхан шатны ухаалаг утсанд тохирсон хялбаршуулсан интерфэйсээр үйлчилгээ үзүүлдэг. Jio-ийн өргөн хүрээтэй экосистемд байр суурь эзэлснээр энтертайнмент, жижиглэн худалдаа, санхүүгийн үйлчилгээг хооронд нь уялдуулах боломжийг олгож, Энэтхэгийн дижитал экосистемийг бий болгох онцлог арга барилыг харуулж байна.

#### 7. AIRTEL MONEY

Airtel Money нь Bharti Airtel компанийн харилцаа холбооны сүлжээнд тулгуурлан Африкийн 14 улсад үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү платформ нь валютын хэлбэлзэл өндөртэй бүс нутгуудад онцгой хэрэгцээтэй олон валютын гүйлгээний боломжоороо өрсөлдөгчдөөсөө ялгардаг. Зөвхөн хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээ бус Airtel Money нь нийлүүлэлтийн сүлжээний төлбөрт зориулсан тусгай бизнес шийдлүүдийг хөгжүүлсэн. Түүнчлэн тус компани хөдөө аж ахуйн төлбөрийн системээрээ дамжуулан фермерүүдийг худалдан авагчидтай шууд холбож орон нутгийн зуучлагчдын хэрэгцээг бууруулсан.

#### 6. BKASH

bKash нь BRAC Bank-ийн удирдлага дор, Robi Axiata компанитай хамтран ажилладаг платформ бөгөөд дэд бүтцийн хүндрэл бэрхшээлтэй байсан ч маш их хэмжээний гүйлгээг удирдаж чаддаг. Энэхүү үйлчилгээ нь тус улсын эдийн засгийн гол тулгуур болсон оёдлын үйлдвэрийн ажилчдад зориулсан цалин хөлс, хөдөө орон нутгийн гэр бүл рүү илгээдэг мөнгөн гуйвуулгыг хялбаршуулах тусгай хэрэгслүүдийг анхлан нэвтрүүлсэн. bKash нь улирлын үерт автдаг Бангладешийн нөхцөл байдалд шинэлэг шийдэл болгон хөвөгч агент завь ашиглан алслагдсан бүс нутгийн иргэдэд хүрч ажилласан. Түүнчлэн тус платформын

худалдаачдын QR кодын систем нь төлбөр тооцоог хотын төвөөс гадна хөдөө, орон нутагт хүртээмжтэй болгож өөрчилсөн бол боловсролын төлбөрийн функц нь сургуулийн төлбөр хураамжийг хялбаршуулснаар Бангладешийн хөгжлийн зорилтуудыг дэмжиж байна.

## 5. VODAPAY

VodaPay нь Vodacom (Vodafone Group-ийн нэг хэсэг)-оос 2021 онд Өмнөд Африкт нэвтрүүлсэн цогц супер апп бөгөөд уламжлалт мобайл мөнгөний үйлчилгээг даван гарсан шийдэл юм. VodaPay нь дижитал санхүүгийн үйлчилгээг е-худалдаа, амьдралын хэв маягтай холбоотой үйлчилгээ болон бизнесийн хэрэгслүүдтэй хослуулсан. Хэрэглэгчид энэ апп-аар мөнгө шилжүүлэх, төлбөр төлөх, нэгж худалдан авах, онлайнаар худалдан авалт хийх, зээл болон даатгал зэрэг санхүүгийн үйлчилгээнд хандах боломжтой. Энэхүү платформ нь Vodacom-ын Alibaba-гийн Ant Financial-тай хийсэн түншлэлийн хүрээнд Alipay технологийг ашигладаг. Нэвтрүүлсэн цагаасаа хойш **VodaPay** нь Өмнөд Африкт хэдэн сая хэрэглэгчтэй болж, **Vodacom**-ын Африкийн зах зээлд хэрэгжүүлж буй өргөн хүрээтэй финтек стратегийн нэг хэсэг болж байна.

## 4. GCASH

Филиппиний **GCash** нь гар утсыг виртуал түрийвч болгон хувиргадаг бөгөөд тус улсын хэмжээнд танигдсан ногоон өнгийн онцгой загвартай интерфейсээрээ алдартай. Энэхүү платформ нь байнга тохиолддог хар салхи зэрэг Филиппинчүүдийн өвөрмөц сорилтуудад зориулсан гамшгийн тусламжийн сувгууд болон гэр бүл дэмжих механизмуудаар дамжуулан тухайн орны онцлог асуудлуудад шууд хариу өгч чаддаг. **GCash** нь орон нутгийн хэрэглээний үйлчилгээ, төрийн байгууллагууд, тээврийн системтэй гүнзгий уялдан ажиллаж, хот суурин газрын зайлшгүй шаардлагатай дэд бүтэц болж чаджээ. Түүнчлэн, **GCredit** болон **GSave** функцүүдээр дамжуулан банкны үйлчилгээнд хамрагдах боломжгүй хүн амд зээл, хадгаламжийн албан ёсны бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлсэн. Мөн түүний ойн хамгааллын санаачилга нь санхүүгийн гүйлгээг байгаль орчны нөлөөтэй холбож, хүрээлэн буй орчныг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулж байна.

## 3. MTN MOBILE MONEY

MTN Mobile Money нь MTN группийн өргөн цар хүрээтэй харилцаа холбооны сүлжээнд тулгуурлан Африкийн 16 улсад үйл ажиллагаа явуулдаг. Өрсөлдөгчид голчлон хот суурин газарт төвлөрдөг бол MTN нь стратегийн хүрээнд өргөн уудам, банкны дэд бүтэц султай бүс нутаг болон зэвсэгт мөргөлдөөнд

нэрвэгдсэн Өмнөд Судан зэрэг орнуудад үйлчилгээнийхээ цар хүрээг тэлжээ. Энэхүү платформын худалдааны төлбөрийн систем нь орон нутгийн валютыг дэмжихийн зэрэгцээ хил дамнасан хэрэглэгчийн туршлагыг ижил түвшинд хадгалдаг. MTN-ийн MoMo Pay QR кодын систем нь жижиг худалдаачдын гүйлгээг стандартчилсан бол, төрийн байгууллагуудтай хийсэн API нэгтгэл нь хэд хэдэн улсад тэтгэвэр олголтыг хялбаршуулж байна.

## 2. ORANGE MONEY

Orange Money нь франц хэлт Африкийн бүс нутагт санхүүгийн чухал холбогчийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Сенегалаас Мадагаскар хүртэлх 17 улсад үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү платформ нь Orange компанийн харилцаа холбооны дэд бүтцийг ашиглан зөвхөн энгийн шилжүүлэг төдийгүй гадаадад байгаа иргэдэд зориулсан олон улсын мөнгөн гуйвуулга зэрэг өргөн хүрээтэй үйлчилгээг санал болгодог. Orange Money-ийн гол давуу тал нь хил дамнасан гүйлгээг хялбар, шуурхай хийх боломж бөгөөд энэ нь Orange-ийн сүлжээнд багтдаг хөрш орнуудын хооронд саадгүй гүйлгээ хийх нөхцөлийг бүрдүүлдэг. Уг үйлчилгээ нь Баруун Африкийн эдийн засгийн төвүүдэд онцгой ач холбогдолтой болж, улс хоорондын худалдааг хөнгөвчлөхөд чухал үүрэг гүйцэтгэж байна.

## 1. M-PESA

M-Pesa нь 2007 онд Кенид Safaricom (Vodafone-тай хамтран) компаниас нэвтрүүлсэн бөгөөд Африкт гар утсанд суурилсан мөнгөний үйлчилгээний анхдагч болсон. Энгийн SMS-д суурилсан мөнгөн шилжүүлгийн систем нь уламжлалт банкны данс шаардалгүйгээр гүйлгээ хийх боломжийг олгосноор санхүүгийн хүртээмжийг эрс өөрчилсөн. M-Pesa-гийн агентын сүлжээ нь хэрэглэгчид бэлэн мөнгө байршуулж, гаргаж авах боломжтой жижиг дэлгүүрүүдээр дамжин ажилладаг бөгөөд энэ нь ялангуяа орон нутагт үр дүнтэй дэд бүтэц болж чаджээ. Уг үйлчилгээ нь улмаар Танзани, Мозамбик, Ардчилсан Конго, Лесото, Гана, Египет болон Азийн зарим бүс нутагт өргөжин тэлж, жил бүр хэдэн тэрбум гүйлгээ боловсруулах болсон бөгөөд санхүүгийн шинэлэг шийдлийн жишээ болон нэрлэгддэг.

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### МОНГОЛ УЛСАД ГАДААД БРОКЕР ОРЖ ИРЭХ, ЗАЙНААС ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

#### Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны ЗЗСХГ-ын ахлах мэргэжилтэн Х.Нинжбадгар

#### ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих, зах зээлийн өсөлтийг хурдасгах, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино. Үүний хүрээнд зохицуулагч байгууллагуудын хил дамнасан санхүүгийн зуучлалын зохицуулалтыг харьцуулан судалж, Монгол Улсад тохиромжтой эрх зүйн орчны загварыг тодорхойлохыг зорьсон. Тус судалгааг хийж гүйцэтгэхдээ дотоодын үнэт цаасны компаниудаас ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ)-ийн статистик мэдээлэлд үндэслэн дүгнэлт гаргасан. Мөн олон улсын сайн туршлагыг судлахдаа Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-аас гаргасан зохицуулалтын орчны олон улсын стандартыг харьцуулан шинжилж, дүгнэлт гарган санал, зөвлөмж боловсруулсан болно.

#### УДИРТГАЛ

2024 оны 2 дугаар улирлын байдлаар Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 11.3 их наяд төгрөгт хүрсэн ба 70 гаруй шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд нэвтрээд байна. Зах зээл өргөжин тэлэхийн хирээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцох идэвх сонирхлыг нэмэгдүүлэх, зайны брокерын зохицуулалтын орчныг бий болгох шаардлага тулгараад байна. 1990 – 2024 оныг хүртэлх хугацаанд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцогчдын 0.08 хувийг гадаадын иргэд эзэлж байгаа нь хөрөнгийн зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зохицуулалтын орчин нарийн төвөгтэй байгааг илтгэж байна.

Гадаад улсын иргэн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцохын тулд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд (ҮЦТХТ) үнэт цаасны данс нээлгэснээр арилжаанд оролцох эрх нээгдэнэ. Анх удаа арилжаанд оролцохоор үнэт цаасны дансыг гадаад улсын иргэн Үнэт цаасны компани (ҮЦК)-иар дамжуулан, эсвэл өөрийн биеэр ҮЦТХТ-д очиж нээлгэнэ. Хэрэв ҮЦК-иар дамжуулан онлайн арилжаанд данс нээлгэх тохиолдолд харилцагчийн гарын үсгийн баталгааг нотариатаар баталгаажуулахыг шаарддаг. Ингэснээр гадаад хөрөнгө оруулагч заавал өөрийн биеэр ирэх шаардлага тулгардаг. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд татах, зах зээлийн хөгжилд тулгарч буй томоохон бэрхшээлүүдийн нэг юм. Иймд энэхүү судалгаагаар Монгол Улсын хөрөнгийн зах зээл оролцож буй гадаадын хөрөнгө оруулагчдийн өнөөгийн байдал ба тэдний зах зээлд, мөн АНУ, Австрали, Канад, Япон, Мексик, Сингапур зэрэг улсуудын хил дамнасан зуучлагчийн зохицуулалтын талаар тусгасан болно.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-с гаргасан судалгаанд дурдсанаар Олон улсад зохицуулагч байгууллагуудын зүгээс хил дамнасан зуучлагчийг түгээмэл 2 аргаар зохицуулдаг байна. Нэгдүгээрт мэргэжлийн хөрөнгө оруулагчийг зах зээлийн үйл ажиллагаанд харьяаллын шаардлага тавихгүй шууд нэвтрүүлэх, Хоёрдугаарт нэг талын буюу харилцан хүлээн зөвшөөрөх арга буюу тухайн улсын зохицуулагч байгууллагатай хамтран ажиллаж хяналт, тусгай шаардлагыг хамтран хэрэгжүүлэх юм.

## ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ҮЦТХТ–д нээгдсэн дансны тайланд дурдсанаас 1990 оны 01 дүгээр сарын 01–ээс 2024 оны 03 дугаар сарын 31–ний өдрийг хүртэл нийт 3,028,396 данс нээгджээ. Хүснэгт 1–д ҮЦТХТ–д нээгдсэн дансыг харилцагчийн төрлөөр ангилан харвал Монгол Улсын иргэн 3,022,227 данс буюу нийт дансны 99.8 хувь, гадаад улсын иргэн 2,549 данс буюу нийт дансны 0.08 хувь, Монгол Улсын ААН 3,401 буюу нийт дансны 0.11 хувь, гадаад улсын ААН 219 данс буюу 0.01 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт. ҮЦТХТ–д нээгдсэн дансны харилцагчийн төрөл

Харилцагчийн төрөл			
Иргэн		ААН	
Монгол	Гадаад	Монгол	Гадаад
3,022,227	2,549	3,401	219
99.8%	0.08%	0.11%	0.01%




Эх сурвалж: ҮЦТХТ Данс нээсэн хураангуй тайлан 1990–2024 он

Дээрх мэдээллээс дүгнэвэл нийт харилцагчийн 0.08 хувийг гадаадын иргэн эзэлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчийг зах зээлд татан оролцуулах, одоогийн бодлого, зохицуулалтын орчинд өөрчлөлт оруулах, гадаадын иргэнд арилжаанд оролцоход тавигдах нөхцөл, шаардлагыг багасгах шаардлагатай байгааг харуулж байна.

Гадаадын иргэдийн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцоход тавигдах шаардлагыг судлах зорилгоор ҮЦК–тай холбогдож дараах судалгааг авлаа.

### Гадаадын иргэн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох үе шат:

Хүснэгт. Гадаад улсын иргэн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох үе шат

<p>Алхам 1. </p> <p>ҮЦТХТ–д бүртгэлтэй Үнэт цаасны данс нээлгэсэн байх</p>	<p>ҮЦТХТ–д үнэт цаасны данс нээхэд өөрийн биеэр очиж эсвэл ҮЦК–аар дамжуулан нээлгэх боломжтой. ҮЦТХТ API системээр дамжуулан дансны мэдээллийг үнэт цаасны компаниудаас цахимаар хүлээн авах ба үнэт цаасны дансны мэдээллийг “ХУР” системээр дамжуулан автоматаар шалгаж баталгаажуулдаг. Гадаадын иргэний хувьд данс нээх гэрээ, гадаад паспортын хуулбар болон бусад холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн байх шаардлагатай бөгөөд гарын үсгийн баталгааг нотариатаар батлуулсан байх шаардлагатай.</p>
<p>Алхам 2. </p> <p>ҮЦК–тай гэрээ байгуулсан байх</p>	<p>Энэ үе шат харьцангуй хялбар бөгөөд ҮЦК–ийн аппликейшнээр дамжуулан зайнаас /онлайн/ бүртгүүлэх боломжтой бол зарим компани заавал өөрийн биеэр ирж гэрээ байгуулахыг шаарддаг.</p>
<p>Алхам 3. </p> <p>Төлбөрийн шилжүүлэг, гадаад гүйлгээ</p>	<p>Гадаадын иргэн төлбөрийн шилжүүлэг, гүйлгээг хийхдээ аль ч банкны дансаар дамжуулан ҮЦК–руу шилжүүлэг хийх боломжтой бөгөөд ҮЦК–иас хариу шилжүүлэг хийхэд тухайн иргэний өөрийн нэр дээрх данс байхыг шаарддаг.</p>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт /ҮЦК–иудаас утсаар авсан мэдээлэл/

## ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

### 1. Хил дамнасан арилжааны олон улсын зохицуулалт

IOSCO нь санхүүгийн зуучлагчдын хил дамнасан үйл ажиллагаа явуулах сонирхол нэмэгдсэн, онлайн /зайны/ брокерын үйл ажиллагаа хурдацтай өсөж байгаатай холбоотойгоор дэлхийн улс орнуудын хил дамнасан арилжааны зохицуулалтын орчны харьцуулсан судалгааг хийсэн. Хил дамнасан үйл ажиллагаа нь тухайн улсад оффисгүй, ажилчингүй, тухайн улсаас хилийн гадна үйл ажиллагаа бөгөөд дэлхийн улс орнууд хил дамнасан арилжааг зохицуулахдаа харилцан адилгүй зохицуулалттай байна.

Хил дамнасан арилжааны зохицуулалтын зорилго:

- ◆ Хэрэглэгчийг хамгаалах;
- ◆ Ил тод зах зээлийг хөгжүүлэх;
- ◆ Системийн эрсдэлийг бууруулах;
- ◆ Харилцагчийн хөрөнгийг хамгаалах;
- ◆ Үнэт цаасны компани болон хэрэглэгчийн хооронд үр дүнтэй харилцааг бий болгох;
- ◆ Мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулах / үнэнч шударга байдал, ур чадвар зэрэгт тохирсон, зохистой, санхүүгийн хувьд сайн шинж чанарууд/;
- ◆ Үйлчилгээ үзүүлэх шударга мэргэжлийн харилцааны өндөр стандартыг баримтлах;
- ◆ Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг бий болгох;
- ◆ Үнэн зөв эх сурвалж, журам тогтоох, бусад шаардлагууд.

IOSCO-ын харьцуулсан судалгааны үр дүнд хил дамнасан арилжааг дэлхийн улс орнууд зохицуулахдаа харилцан адилгүй зохицуулдаг. Хил дамнасан арилжааг дотоодын зах зээлд нэвтрүүлсэн улс орнуудаас түгээмэл хоёр үндсэн зохицуулалтын арга байх бөгөөд судалгаанд хамрагдсан улс орнуудын зохицуулалтын шаардлагыг тусгасан болно.

### 2. Мэргэжлийн хөрөнгө оруулагчийн арга

Мэргэжлийн хөрөнгө оруулагчийн арга нь дотоодын зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчийг нэвтрүүлэхдээ бүрэн мэргэшсэн, хангалттай хөрөнгөтэй хөрөнгө оруулагчдад дотоодын үнэт цаасны зохицуулагч байгууллагын зүгээс тусгай зөвшөөрөл олгохдоо тавиглах шаардлагыг бүрэн хангасан байхыг шаардахгүйгээр тодорхой шаардлагаас чөлөөлөн зах зээлд оролцох эрхийг өгдөг. АНУ болон Канад Улсуудад тухайн улсын Үнэт цаасны тухай хуульд зааснаар мэргэжлийн хөрөнгө оруулагчийн аргыг ашиглаж байна.

#### Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

АНУ-ын үнэт цаасны биржийн хороо /SEC/ –ны 15a–6–р журмын дагуу “АНУ-ын үнэт цаасны биржийн хороонд брокер–дилерээр бүртгүүлээгүй мэргэжлийн хөрөнгө оруулагч нь АНУ–д үнэт цаасны зах зээлийн хуульд заасан тодорхой үйл ажиллагаа явуулж болно.” гэж заасан.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчийн төрөл:

1. АНУ-ын байгууллагын хөрөнгө оруулагч (U.S. institutional investor) – бүртгэлтэй хөрөнгө оруулалтын компаниуд, банкнууд болон хадгаламжийн банкнууд, даатгалын компаниуд мөн АНУ-ын зарим аж ахуйн нэгжүүд.
2. АНУ-ын томоохон байгууллагын хөрөнгө оруулагч (Major U.S. institutional investor)– 100 сая доллароос дээш хөрөнгөтэй, АНУ-ын байгууллагын хөрөнгө оруулагч (U.S. institutional investor).

#### Канад Улс

Онтарио (Канад)–д гадаадын санхүүгийн зуучлагчийг "олон улсын дилер" гэж хүлээн зөвшөөрч, дотоодын тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангахгүйгээр Онтариод үйл ажиллагаа явуулах боломжтой.

Үнэт цаасны тухай хуульд (Онтарио): "Олон улсын дилер" гэдэг нь гадаад үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг худалддаг, тусгайлсан байгууллага руу, зорилтот зах зээл рүү чиглэсэн мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай /банкнууд, даатгалын компаниуд/ үйл ажиллагаа явуулдаг компани эсвэл хувь хүн байна.

### 3. Нэг талыг болон харилцан хүлээн зөвшөөрөх арга

Нэг талыг болон харилцан хүлээн зөвшөөрөх арга нь хоорондоо ижил төстэй бөгөөд зохицуулагч байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалж байгаа тохиолдолд нэг талыг хүлээн зөвшөөрөх аргыг, харин тухайн гадаадын зуучлагчийн харьяаллын шаардлагыг харилцан хүлээн зөвшөөрч, дотоодын шаардлагыг чөлөөлөх тохиолдолд харилцан хүлээн зөвшөөрөх аргыг ашигладаг. Харилцан хүлээн зөвшөөрөх аргыг Австрали Улс нь хил дамнан арилжааг зохицуулахдаа ашиглаж байна.

**Нэг талыг хүлээн зөвшөөрөх арга** нь тухайн улсын дотоодын зохицуулалтын шаардлага, нөхцөл нь гадаадын зуучлагчдад ерөнхийдөө үйлчилдэггүй. Дотоодын зохицуулалтын орчинд орохдоо гадаадын зуучлагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд дотоодын харьяаллын шаардлагыг хэрэгжүүлэх боломжтой.

**Харилцан хүлээн зөвшөөрөх арга** нь нэг талыг хүлээн зөвшөөрөх аргатай төстэй. Өөрийн харьяаллын шаардлагыг хангасан зуучлагчид гадаад зах зээлд үйл ажиллагаа явуулахдаа тухайн улсын зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөхгүй үйл ажиллагаа явуулж болно. Энэ нь гадаадын зуучлагч өөрийн улсын зохицуулагч байгууллагын харьяалалд үйл ажиллагаа явуулж байгаа бол харилцан хүлээн зөвшөөрч өөрийн шаардлагаас чөлөөлдөг. Тухайн улсын харьяаллын шаардлагад бусад улсын зохицуулалтын орчинд бэлтгэгдсэн хөрөнгө оруулагч байх, зах зээлийг хамгаалах зэргийг онцлон авч үздэг.

#### Австрали Улс

Австралийн Үнэт цаас, Хөрөнгө оруулалтын хороо (ASIC) нь нэг талыг болон харилцан хүлээн зөвшөөрөх аргыг ашиглан гадаадын зуучлагчдыг зохицуулдаг бөгөөд гадаадын зуучлагчдыг бүртгэхдээ Австралийн үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу дараах хүчин зүйлсийг авч үздэг байна. Үүнд:

1. Өргөдөл гаргагчийн мэдээллийг шалгах – Гадаадын зуучлагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн түүх болон хууль зүйн харьяаллын шаардлагуудыг шалгах.
2. Олон улсын хамтын ажиллагааны туршлага – ASIC нь тухайн зуучлагчийн өөрийн улсын зохицуулагч байгууллагатай хамтран ажилласан туршлагыг харгалзан үзэх бөгөөд хамтын ажиллагааны туршлага нь зохицуулалтын үр нөлөөг сайжруулж, мэдээлэл солилцооны үр дүнтэй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.
3. IOSCO-ийн тайлан болон судалгаа – ASIC нь IOSCO-оос гаргасан судалгааны тайлан болон бусад холбогдох баримт бичгүүдэд тулгуурлан гадаадын зуучлагчийн зохицуулалтын шаардлага, стандартуудыг харьцуулан үнэлдэг.
4. ASIC-ийн мэдээлэл – Дээрх судалгааны болон хамтын ажиллагааны үр дүнд цуглуулсан мэдээлэлд тулгуурлан гадаадын зуучлагчийн үйл ажиллагаа Австралийн зах зээлд хэрхэн нийцэж байгаа эсэхийг тодорхойлдог.

Үүний дараа ASIC нь тухайн гадаадын зуучлагчид тавигдах Австралийн үнэт цаасны хууль тогтоомжид заасан зохицуулалтын шаардлагуудыг тодорхой хэмжээнд чөлөөлөх эсэх талаар шийдвэр гаргадаг. Зохицуулалтын шаардлагаас чөлөөлөхдөө гэрээний шаардлага болон шүүхийн нэмэлт шаардлагуудыг тавьдаг.

1. Дотоодын зуучлагчийн оролцоо – Гадаадын зуучлагч нь Австралийн хөрөнгө оруулагчдын өмнөөс арилжаанд оролцохдоо дотоодын буюу Австралид үйл ажиллагаа эрхэлдэг зуучлагчтай гэрээ байгуулсан байх шаардлагатай.
2. Австралийн шүүхийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх – Гадаадын зуучлагч нь өөрийн үйл ажиллагаанд Австралийн хууль, шүүхийн шаардлагыг хүлээн зөвшөөрч, ямар нэгэн маргаан гарсан тохиолдолд Австралийн шүүхэд харьяалагдах боломжийг нээлттэй байлгах ёстой.

Дээрх шаардлагыг хангасан гэж ASIC үзсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлж, гадаадын зуучлагчид Австралийн хөрөнгө оруулагчдад тодорхой үйлчилгээ үзүүлэх боломжтой болох юм.

## ДҮГНЭЛТ

Дэлхийн улс орнууд хил дамнасан арилжааны зохицуулалтад харилцан адилгүй нөхцөл, шаардлагыг гадаадын зуучлагчдад тавьж байна. Зарим улс орнууд хил дамнасан арилжааг бүрэн хориглодог. Тухайлбал, Мексик, Япон Улсуудад гадаадын зуучлагчдыг тухайн улсад заавал биечлэн байхыг шаардаж хил дамнасан арилжааг хориглодог бол зарим нь дотоодын зохицуулалтын шаардлагаас (жишээлбэл, тусгай зөвшөөрөл олгох) чөлөөлөх бодлого баримталдаг.

Гадаадын зуучлагчдыг дотоодын зах зээлд нэвтрүүлэхэд дэлхийн улс орнууд дараах хоёр үндсэн аргыг ашиглаж байна:

1. Мэргэжлийн хөрөнгө оруулагчийн арга: Энэ нь зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд шууд нэвтрүүлэх боломжийг олгодог.
2. Нэг талыг болон харилцан хүлээн зөвшөөрөх арга: Энэ аргаар тухайн улсын зохицуулагч байгууллага нь гадаадын зохицуулагч байгууллагатай хамтран ажиллаж, шаардлага хангаж буй гадаадын хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд нэвтрэхийг зөвшөөрдөг.

Мөн зарим улс орнууд дээрх хоёр аргыг хослуулан ашигладаг. Жишээлбэл, Сингапур Улс хилээс гадна үйл ажиллагаа эрхэлж буй гадаадын зуучлагчдад дотоодын зохицуулалтын шаардлагыг тавихдаа тухайн зуучлагчийн туршлага болон гадаадын зохицуулагч байгууллагын үнэлгээг харгалзан үздэг. Энэ нь тусгай зөвшөөрлийн шаардлага зэрэг дотоодын зохицуулалтын үндсэн зарчмуудыг давхар хангахад чиглэгддэг.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ IOSCO. Regulation of remote cross-border financial intermediaries. February, 2004. Rerrived from: <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD162.pdf>
- ◆ Interactive Brokers онлайн брокер Rerrived from: <https://www.interactivebrokers.com/e>
- ◆ Euroclear банк Rerrived from: <https://www.euroclear.com/>
- ◆ АНУ-ын үнэт цаасны биржийн хороо /SEC/ –ны журам. 2013. Rerrived from: <https://www.sec.gov>
- ◆ Австрали Улсын хил дамнасан арилжааны зохицуулалтын журам. 2012. Rerrived from: <https://download.asic.gov.au/>
- ◆ Монгол Улсын Гадаад харилцааны яам, Консулын газар. Rerrived from: <https://www.consul.mn>
- ◆ Монгол Улсын хууль, Нотариатын тухай. 2019. Rerrived from: <https://legalinfo.mn/>
- ◆ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв. Хууль, журам. Rerrived from: <https://www.mcsd.mn>



## REIT БУЮУ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ГЭЖ ЮУ ВЭ?



**REIT /Real estate investment trust/** нь үл хөдлөх хөрөнгө худалдан авч борлуулах, түрээслэх хэлбэрээр орлого олдог, ногдол ашиг хуваарилдаг, эрсдэл багатай, тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэл юм.



REIT нь нээлттэй, хаалттай хэлбэрээр байдаг бөгөөд хамтын хөрөнгө оруулалтын сангийн адилаар нэгж эрх гаргаж, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийн эх үүсвэр татдаг, нэгж эрх нь олон нийтийн дунд нээлттэй арилжаалагддаг.

## REIT-ЫН ДАВУУ ТАЛ



Тогтмол өгөөжтэй



Эрсдэл багатай



Хөрвөх чадвар өндөртэй



Хөрөнгө оруулалтын багцаа  
төрөлжүүлэх боломжтой.



REIT-ын менежментийг үл хөдлөх хөрөнгөөр мэргэшсэн, хөрөнгийн удирдлагын компани хийдэг.

## REIT-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГА ААНД ОРОЛЦОГЧИД



REIT-ын менежер

REIT-ын хөрөнгийг удирдаж, үл хөдлөх хөрөнгө худалдан авах эрх, үүргийг хэрэгжүүлдэг.



Үл хөдлөх  
хөрөнгийн менежер

Үл хөдлөх хөрөнгийн маркетинг, сурталчилгаа болон засвар үйлчилгээтэй холбоотой эрх, үүргийг хэрэгжүүлдэг.



Trustee буюу  
ИТГЭМЖЛЭГДСЭН ӨМЧЛӨГЧ

REIT-ын нэрийн өмнөөс хөрөнгө эзэмших үүрэгтэй ба нэгж эрх эзэмшигчдийн ашиг сонирхлыг төлөөлдөг.

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ХЯТАДЫН ДЕФЛЯЦИЙН АСУУДАЛ УЛАМ ДОРДОЖ БАЙНА.



Хятадад өргөн хэрэглээний барааны үнэ сүүлийн жил гаруйн хугацаанд хамгийн доод түвшиндээ хүрч буурсан нь дэлхийн хоёр дахь том эдийн засагт дефляцийн дарамт үргэлжилсээр байгааг харуулж байна. Хятадын Үндэсний Статистикийн Товчоо (NBS) инфляцыг хэмжих жишиг үзүүлэлт болох хэрэглээний үнийн индекс хоёрдугаар сард өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурчээ.

Үүний зэрэгцээ бөөний үнийг хянадаг Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) хоёрдугаар сард өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар буурсан байна. Factory-gate үнэ 2022 оны аравдугаар сараас хойш 29 сар дараалан буурч байна.

Goldman Sachs-ийн эдийн засагчдын хийсэн судалгааны тайланд "Улирлын түр зуурын гажуудлыг эс тооцвол сүүлийн хоёр жилийн хугацаанд ХҮИ болон PPI инфляц хэт бага байсан нь Хятадын эдийн засаг дахь эрэлт нийлүүлэлтийн тэнцвэргүй байдлыг онцолж байна" гэж бичжээ.

Эх сурвалж: [www.CNN.com](http://www.CNN.com)

### ХУДАЛДААНЫ ХУРЦАДМАЛ БАЙДАЛ НЭМЭГДЭХИЙН ХЭРЭЭР АЛТНЫ ҮНЭ 3,000 АМ.ДОЛЛАРТ ХҮРЭВ.



Дэлхийн худалдааны дайны нөлөөгөөр эдийн засгийн тодорхойгүй байдлын улмаас үнэт металлын эрэлт нэмэгдэж алтны үнэ анх удаа унц нь 3,000 ам.долларт хүрлээ. Алт нь хөрөнгө оруулагчдын хувьд илүү найдвартай хөрөнгө гэж үздэг бөгөөд эдийн засгийн тогтворгүй байдлын үед эрэлт нь ихэсдэг.

АНУ болон түүний худалдааны хамгийн том түншүүдийн хооронд хурцадсан худалдааны дайн нь санхүүгийн зах зээлийг тогтворгүй болгож, дэлхийн эдийн засаг, хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийн талаарх санаа зовнилыг төрүүлэв. Импортын бараа, бүтээгдэхүүнд ногдуулж буй тариф нь үнийн хөөрөгдөлд хүргэж болзошгүй гэсэн айдсаас үүдэн хөрөнгө оруулагчид алтанд хөрөнгө оруулах нь нэмэгдэж байна. Бараа, бүтээгдэхүүнд татвар ногдуулснаар бизнес эрхлэгчид нэмэлт зардал хүлээх бөгөөд энэ нь эцсийн дүндээ хэрэглэгчдэд борлуулж буй барааны үнийн өсөлтөөр дамжин, амьжиргааны өртгийг нэмэгдүүлнэ.

Эх сурвалж: [www.BBC.com](http://www.BBC.com)

### ЭХ ГАЗРЫН ХЯТАДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ХОНГ КОНГИЙН ХУВЬЦААГ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ САЛБАРТ ТОГЛОХ ЗОРИЛГООР ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ ХЭМЖЭЭГЭЭР ХУДАЛДАН АВЧЭЭ.



Хятадын эх газрын хөрөнгө оруулагчид Хонг Конгийн хөрөнгийн зах зээлд шинэ дээд амжилт тогтоолоо. 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Хятадын эх газрын хөрөнгө оруулагчид Хонг Конгийн хувьцааг нийт 29.62 тэрбум Хонг Конг доллар (ойролцоогоор 3.81 тэрбум ам.доллар)-ын цэвэр худалдан авалт хийж, түүхэн дээд амжилт тогтоожээ.

Энэ нь Хонг Конгийн хөрөнгийн зах зээл эх газрын зах зээлтэй "холбох" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойших хамгийн өндөр үзүүлэлт байлаа. Энэхүү хөтөлбөр нь дотоодын хөрөнгө оруулагчдад Хонг Конг арилжаалагдаж буй тодорхой хувьцаанд хялбархан хандах боломжийг олгож байна.

Хонг Конг арилжаалагддаг Алибаба, Tencent зэрэг компаниудын хувьцаа хамгийн их цэвэр худалдан авалттай байсан бөгөөд эдгээр хувьцаа эх газрын Хятадад арилжаалагддаггүй гэж Wind-ийн

мэдээлэлд дурджээ.

Өнгөрсөн долоо хоногт Хятад Улс хувийн хэвшлийн технологийн инновацыг дэмжих төлөвлөгөөг онцлон зарласан. Үүний зэрэгцээ, төсвийн алдагдлаа дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувьтай тэнцэх хэмжээнд хүргэж, өргөн хэрэглээний татаасны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон нь эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой юм.

Эх сурвалж: [www.CNBC.com](http://www.CNBC.com)

**ТРАМПЫН ИМПОРТЫН ГАН, ХӨНГӨН ЦАГААНД НОГДУУЛСАН 25 ХУВИЙН ТАТВАР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛЖ, ЕВРОП ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВЧ БАЙНА.**



АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын импортын ган, хөнгөн цагаанд ногдуулах 25 хувийн гаалийн татвар 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн тул үүнд Европын холбооноос шуурхай арга хэмжээ авчээ.

Европын холбоо дөрөвдүгээр сараас эхлэн АНУ-ын 26 тэрбум евро буюу 28.33 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнд сөрөг татвар ногдуулна гэж мэдэгдэв. Сөрөг арга хэмжээ нь "Европын бизнес эрхлэгчид, ажилчид, хэрэглэгчдийг эдгээр үндэслэлгүй худалдааны хязгаарлалтын нөлөөллөөс хамгаалах зорилготой" гэж Европын комиссын мэдэгдэлд дурджээ.

Европын холбооны хоёр талт арга барил нь АНУ-ын 8 тэрбум еврогийн экспортын бараанд өмнө нь түдгэлзүүлсэн гаалийн татварыг сэргээж, 18 тэрбум еврогийн бараанд хэд хэдэн шинэ эсрэг арга хэмжээ авахаа Европын Комиссын ерөнхийлөгч Урсула фон дер Лейен "хүчтэй боловч пропорциональ" гэж тодорхойлсон байна.

Эх сурвалж: [www.CNBC.com](http://www.CNBC.com)

WORLD FINANCE

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр

S&P 500 / ^GSPC/

**5,693.31** -18.89 (-0.33%)



Nikkei 225 / ^N225/

**37,008.94** -782.55 (-2.07%)



FTSE 100 / ^FTSE/

**8,666.07** -23.47 (-0.27%)



NASDAQ Composite (^IXIC)

**17,804.03** -94.98 (-0.35%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

ШУДАРГА ЕС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

# 110

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС  
/үнэ төлбөргүй/

АВАГ А  
110  
ХИНА СУТГА  
110  
АНИТ СОЁРЛАХ  
110

АВИАТАР  
ТӨВӨХ ГАЗАР